



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/18/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Аудитор:

Утас: 70512127

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

А.Мөнхцэцэг

Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|-------------------------------------|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 6 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 9 |
| 3. Аудитын тайлан..... | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 10 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Материаллаг байдал | 11 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 13 |
| 3.8 Аудитын гол асуудал | 13 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 13 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 4. Аудитын илрүүлэлт | Error! Bookmark not defined. |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.24 № 21

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Ж.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-----------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>21,066,281.65</u> | <u>35,316,914.00</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,000.00 | 00.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 1,000.00 | 00.00 |
| 3121 | Төгрөг | 1,000.00 | 00.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 1,000.00 | 00.00 |
| 33 | АВЛАГА | 8,125,000.00 | 00.00 |
| 335 | Бусад авлага | 8,125,000.00 | 00.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 8,125,000.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 12,940,281.65 | 35,316,914.00 |
| 351 | Түүхий эд материал | 7,569,792.75 | 10,139,544.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,569,792.75 | 10,139,544.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,638,630.00 | 1,993,630.00 |
| 354 | Хангамжийн материал | 3,731,858.90 | 23,183,740.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,823,308.90 | 2,928,940.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,716,050.00 | 8,815,800.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 289,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 192,500.00 | 11,150,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>66,897,859.50</u> | <u>176,453,608.03</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 66,897,859.50 | 176,453,608.03 |
| 392 | Биет хөрөнгө | 56,799,459.42 | 166,937,807.92 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 20,852,370.00 | 20,852,370.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,668,189.60 | -2,502,284.40 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 45,136,866.00 | 171,066,216.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -10,378,251.61 | -25,101,435.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,953,230.00 | 14,243,130.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,096,565.37 | -11,620,187.70 |
| 393 | Биет бус хөрөнгө | 10,098,400.08 | 9,515,800.11 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,652,000.00 | 11,652,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -1,553,599.92 | -2,136,199.89 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>87,964,141.15</u> | <u>211,770,522.03</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>1,000.00</u> | <u>00.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,000.00 | 00.00 |
| 414 | Урьдчилж орсон орлого | 1,000.00 | 00.00 |
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 1,000.00 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>87,963,141.15</u> | <u>211,770,522.03</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 87,963,141.15 | 211,770,522.03 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 11,652,000.00 | 11,652,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 11,652,000.00 | 11,652,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 64,387,719.25 | 188,195,100.13 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 45,685,266.47 | 56,262,719.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 18,702,452.78 | 131,932,380.88 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 11,923,421.90 | 11,923,421.90 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>87,964,141.15</u> | <u>211,770,522.03</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 530,391,203.73 | 644,441,083.87 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 38,735,103.73 | 180,298,183.87 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 38,735,103.73 | 180,298,183.87 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 38,735,103.73 | 180,298,183.87 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 38,735,103.73 | 180,298,183.87 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 491,656,100.00 | 464,142,900.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 372,034,000.00 | 398,935,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 372,034,000.00 | 398,935,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 119,622,100.00 | 65,207,700.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,011,500.00 | 3,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 111,610,600.00 | 61,707,700.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 511,688,750.95 | 512,321,702.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 511,688,750.95 | 512,321,702.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 509,595,855.95 | 511,295,811.31 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 316,683,800.00 | 332,920,418.69 |
| 210101 | Үндсэн цалин | 260,572,225.46 | 234,645,861.26 |
| 210102 | Нэмэгдэл | 49,102,374.54 | 86,969,957.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,009,200.00 | 11,304,600.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,046,800.00 | 43,105,545.63 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,250,896.88 | 30,495,790.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,966,951.74 | 3,175,449.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,373,561.41 | 2,540,419.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 586,853.70 | 626,689.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,868,536.27 | 6,267,196.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,220,000.00 | 5,318,382.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 350,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 2,969,050.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 149,332.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,220,000.00 | 1,850,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,697,803.65 | 28,435,290.90 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,314,596.10 | 5,667,568.90 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,349,200.00 | 2,065,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,568,600.00 | 1,960,312.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 143,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 37,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,285,407.55 | 17,089,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 1,652,910.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,703,500.00 | 2,134,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 138,000.00 | 189,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 554,000.00 | 220,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,011,500.00 | 1,725,000.00 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 159,000.00 | 535,500.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 159,000.00 | 535,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,695,640.25 | 16,515,276.75 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,081,654.00 | 6,141,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 8,613,986.25 | 10,374,276.75 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 116,389,312.05 | 82,331,397.34 |

| | | | |
|-------------|--|-----------------------------|------------------------------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,511,805.00 | 61,707,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 399,100.00 | 324,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,478,407.05 | 20,299,697.34 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,092,895.00 | 1,025,891.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 418,100.00 | 250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 418,100.00 | 250,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,674,795.00 | 775,891.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,674,795.00 | 775,891.68 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>18,702,452.78</u> | <u>132,119,380.88</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 187,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 187,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | -187,000.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>18,702,452.78</u> | <u>131,932,380.88</u> |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|---|
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 11,652,000.00 | 11,923,421.90 | 64,387,719.25 | 00.00 | 87,963,141.15 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 11,652,000.00 | 11,923,421.90 | 64,387,719.25 | 00.00 | 87,963,141.15 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -8,125,000.00 | 00.00 | -8,125,000.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 11,652,000.00 | 11,923,421.90 | 56,262,719.25 | 00.00 | 79,838,141.15 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 131,932,380.88 | 00.00 | 131,932,380.88 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 11,652,000.00 | 11,923,421.90 | 188,195,100.13 | 00.00 | 211,770,522.03 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>618,631,376.74</u> | <u>605,173,577.40</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | <u>126,975,276.74</u> | <u>141,030,677.40</u> |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 126,975,276.74 | 141,030,677.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 126,975,276.74 | 141,030,677.40 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 126,975,276.74 | 141,030,677.40 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | <u>491,656,100.00</u> | <u>464,142,900.00</u> |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 372,034,000.00 | 398,935,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 372,034,000.00 | 398,935,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 119,622,100.00 | 65,207,700.00 |

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,011,500.00 | 3,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 111,610,600.00 | 61,707,700.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 618,630,376.74 | 605,174,577.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 618,630,376.74 | 605,174,577.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 489,563,205.00 | 463,117,008.32 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 316,683,800.00 | 332,920,418.69 |
| 210101 | Үндсэн цалин | 260,572,225.46 | 234,645,861.26 |
| 210102 | Нэмэгдэл | 49,102,374.54 | 86,969,957.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,009,200.00 | 11,304,600.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,046,800.00 | 43,105,545.63 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,250,896.88 | 30,495,790.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,966,951.74 | 3,175,449.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,373,561.41 | 2,540,419.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 586,853.70 | 626,689.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,868,536.27 | 6,267,196.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,220,000.00 | 5,318,382.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 350,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 2,969,050.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 149,332.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,220,000.00 | 1,850,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,351,600.00 | 9,189,462.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,047,600.00 | 3,903,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,349,200.00 | 2,065,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,568,600.00 | 1,960,312.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 37,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,349,200.00 | 1,260,050.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,678,800.00 | 3,875,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 800,500.00 | 630,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 866,800.00 | 520,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,011,500.00 | 2,725,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 159,000.00 | 535,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 159,000.00 | 535,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,088,300.00 | 6,141,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,088,300.00 | 6,141,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,334,905.00 | 62,031,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 109,935,805.00 | 61,707,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 399,100.00 | 324,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 129,067,171.74 | 142,057,569.08 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 418,100.00 | 250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 418,100.00 | 250,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 128,649,071.74 | 141,807,569.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,437,158.00 | 775,891.68 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 1,000.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,000.00 | 00.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 398,935,200.00 | 398,159,308.32 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 398,935,200.00 | 398,159,308.32 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 398,676,000.00 | 397,909,308.32 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 332,206,200.00 | 332,920,418.69 |
| 210101 | Үндсэн цалин | 285,690,500.00 | 234,645,861.26 |
| 210102 | Нэмэгдэл | 39,651,700.00 | 86,969,957.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,864,000.00 | 11,304,600.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,838,700.00 | 43,105,545.63 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,627,200.00 | 30,495,790.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,802,900.00 | 3,175,449.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,242,300.00 | 2,540,419.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 560,600.00 | 626,689.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,605,700.00 | 6,267,196.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,350,000.00 | 5,318,382.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 350,000.00 | 350,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,000,000.00 | 2,969,050.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 150,000.00 | 149,332.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,850,000.00 | 1,850,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,471,900.00 | 9,189,462.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,903,600.00 | 3,903,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,065,500.00 | 2,065,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,198,000.00 | 1,960,312.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 42,500.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,262,300.00 | 1,260,050.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,879,000.00 | 3,875,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 630,000.00 | 630,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 524,000.00 | 520,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,725,000.00 | 2,725,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 537,200.00 | 535,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 537,200.00 | 535,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,961,000.00 | 2,641,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,641,000.00 | 2,641,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 224,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 96,000.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 432,000.00 | 324,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 432,000.00 | 324,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 259,200.00 | 250,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 259,200.00 | 250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 259,200.00 | 250,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 398,935,200.00 | 398,159,308.32 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 398,935,200.00 | 398,159,308.32 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 398,935,200.00 | 398,159,308.32 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 28 | 28 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22 | 22 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|---|----------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 65,207,700.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 65,207,700.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 65,207,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,500,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,500,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 61707700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 61,707,700.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 65207700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 65,207,700.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 61,707,700.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 53 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, бүх шатны бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, хамгаалах, олон улсын гэрээний дагуу хамтрах ажиллах, мэдээ тайланг нэгтгэх улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан бусад чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 511.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 5.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 123.8 сая төгрөг буюу 140.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|----------------|-----------------|--------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.001 | | -0.001 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 12.9 | 35.3 | 22.4 |
| Үндсэн хөрөнгө | 66.9 | 176.4 | 109.5 |
| Нийт хөрөнгө | 87.9 | 211.7 | 123.8 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 87.9 | 211.7 | 123.8 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 87.9 | 211.7 | 123.8 |

- Бараа материалын дансны үлдэгдэл 35.3 сая төгрөг болж 22.4 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материал данс өсөхөд тайлант онд Улсын бүртгэлийн ерөнхий газраас үнэ төлбөргүй 48.8 сая, бусад 1.6 сая, төсвийн хөрөнгөөр 19.1 нийт 69.5 сая төгрөгийн материал нэмэгдсэн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 176.4 сая төгрөг болж 109.5 сая нэмэгдсэн байна. Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төслийн хүрээнд 128.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 3.3 сая төгрөгийн тавилга эд хогшил нэмэгджээ.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 114.0 сая төгрөг буюу 21.5 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Тодруулбал тайланд онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 180.3 сая төгрөг болсон байна. Энэ нь 48.8 сая төгрөгийн материал, 131.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 180.3 сая төгрөгийн хөрөнгө, материал үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 0.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 116.4 сая төгрөгөөр бууруулж 334.7 сая төгрөгөөр баталсан байна. Харин төсвийн тодотголоор тус байгууллагын төсөв 64.2 сая төгрөгөөр нэмэгджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 398.9 сая төгрөгийн төсөв баталснаас 398.9 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 398.9 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны 141.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 398.1 сая төгрөг зарцуулж 0.7 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 61.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 61.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг УБЕГ, аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс хяналт шинжилгээ хийж, хяналт шинжилгээ, үнэлгээгээр 79.1 хувьтай дүгнэгдсэн бол УБЕГ гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 88.8 хувьтай хэрэгжилттэй дүгнэсэн.

Тайлант онд БНСУ-ын ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага "Койка" төслийн хөрөнгөөр Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төслийн хүрээнд 128.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 3.3 сая төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүйгээр нийлүүлж, хөрөнгийн бүртгэлд тусгажээ.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Улсын бүртгэлийн ерөнхий газраас Ковид-19 урьдчилан сэргийлэх зорилгоор үнэ төлбөргүй 48.7 сая төгрөгийн бараа материал ирснийг данс бүртгэлд тусгасан байна. Зарим бараа материалыг тулгахад зах зээлийн үнээс өндөр, их хэмжээгээр нийлүүлсэн байгаа бөгөөд үлдэгдэл их хэмжээтэй байна. Иймд УБЕГ-ын санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийхтэй холбоотой тус материалын хөрөнгийн худалдан авалтад нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх шаардлагатайг уламжилж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд

чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар улсын байцаагч нарын үнэт цаасны жилийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн тайлан, тодруулгад дутуу тайлагнасан 1.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, томилолтын нөхөн олговрыг илүү бодож олгосон 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Дээрхи зөрчлүүдийг бүрэн хэрэгжүүлэн ажиллажээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.